

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 10 дугаар сарын 19-ний өдөр

№ 23/26

Улаанбаатар хот

Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах эрх олгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дахь заалт, 76.2 дахь заалт, 80 дугаар зүйлийн 80.7 дахь хэсэг, 89 дүгээр зүйлийн 89.1 дэх заалт, 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэг, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”) -ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.20 дэх заалт, 20 дугаар зүйлийн 20.1, 20.4, 20.5 дахь хэсэг болон Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн 2023 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн зүгээс өөрийн зээлийн үйл ажиллагааны эрэлтийг хангах, үйл ажиллагааны цаашдын өсөлтийг хадгалах, шаардлагатай үед эх үүсвэрийг тухай бүр авч ашиглах зорилгоор толгой компани “АНД Системс” ХХК-тай байгуулсан “Санхүүжилтийн гэрээ”-д нэмэлт, өөрчлөлт оруулж, 10,000,000,000 (арван тэрбум) хүртэл төгрөгийн болон 3,000,000 (гурван сая) хүртэл ам.долларын зээлийн шугам нээлгүүлэх хүсэлт гаргасантай танилцаад:

- Компанийн зээлийн багц нь 2023 оны III улирлын байдлаар 100.4 тэрбум төгрөг буюу өмнөх оны мөн үеэс 101.9% өссөн, цаашид өсөх боломжтой болохыг харгалзан;
- Компани нь өөрийн зээлийн бүтээгдэхүүний сонголт, төрөлжилтийг нэмэгдүүлж, шинэ зээлийн бүтээгдэхүүн гаргасан бөгөөд тус бүтээгдэхүүнээ зах зээлд үе шаттайгаар нэвтрүүлэхэд эх үүсвэрийн нэмэлт хэрэгцээ байгааг харгалзан;
- Толгой компани “АНД Системс” ХХК-тай байгуулсан гэрээнд оруулах нэмэлт, өөрчлөлтийн нөхцөл нь санхүүгийн зах зээлийн дундаж үнэтэй дүйцэхүйц байгаа бөгөөд зээл олголтын шимтгэл, барьцаа хөрөнгө байхгүй тул Компанид ашигтай болохыг харгалзан;

толгой компани “АНД Системс” ХХК-тай байгуулсан “Санхүүжилтийн гэрээ”-д нэмэлт, өөрчлөлт оруулахаар шийдвэрлэсүгэй.

2. “Санхүүжилтийн гэрээ”-д оруулах нэмэлт, өөрчлөлтийн нөхцөлийг энэхүү тогтоолын хавсралтаар баталж, тус батлагдсан нөхцөлийн дагуу “Санхүүжилтийн гэрээ”-ний нэмэлт, өөрчлөлтөд гарын үсэг зурж баталгаажуулах эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д олгосугай.
3. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг Компанийн ТУЗ-д эргэн тайлагнахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д үүрэг болгосугай.

